


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **3,632.7** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.1

хувь буюу **108.6** сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл **251.4** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	3 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	3,057.4	2,197.4	3,524.1	3,632.7	108.6	3.1
-Экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9
-Импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	167.0	11.0
Тэнцэл	485.9	-125.8	476.7	251.4	-225.3	-47.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **251.4** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 225.3 сая ам.доллар буюу 47.3 хувиар буурахад импорт **167.0** сая ам.доллараар өссөн, экспорт 58.4 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр **1,942.0** сая ам.доллар болж, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 170.4 сая ам.доллар буюу 9.6 хувиар өссөн

бол 2021 оны мөн үетэй харьцуулахад 58.4 сая ам.доллар буюу 2.9 хувиар буурсан байна.

Импорт: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр импорт **1,690.7** сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үетэй харьцуулахад 404.9 сая ам.доллар буюу 13.0 хувиар, 2021 оны мөн үеэс 167.0 сая ам.доллар буюу 11.0 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **78.9** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **21.1** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **1,531.3** сая ам.доллар болж, өмнөх

оноос **244.9** сая ам.доллар буюу 13.8 хувиар буурсан бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 410.7 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 186.5 сая ам.доллар буюу 83.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	3 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,478.9	886.0	1,776.2	1,531.3	-244.9	-13.8	78.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	292.7	149.8	224.2	410.7	186.5	83.2	21.1
Нийт экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 36.6 хувийг зэсийн баяжмал, 34.8 хувийг нүүрс, 14.8 хувийг боловсруулаагүй алт, 3.0 хувийг төмрийн

хүдэр, 2.1 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	3 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	361.4	306.6	316.3	334.8	18.5	5.8
Нүүрс	сая.тн	7.7	3.1	6.7	2.5	-4.1	-62.2
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	2.1	2.1	1.9	0.6	-1.3	-67.8
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	44.0	36.9	31.0	21.9	-9.1	-29.5
Алт	тн	4.7	1.6	0.4	4.8	4.4	989.3
Боловсруулаагүй нефть	сая.баррель	1.6	0.3	1.4	0.0	-1.4	-100.0
Катодын зэс	тн	2.3	3.1	3.3	0.8	-2.5	-76.8
Жоншны баяжмал	мян.тн	110.6	137.1	194.1	50.9	-143.2	-73.8
Адууны мах	мян.тн	5.8	2.7	4.2	0.0	-4.2	-100.0
Өлөн гэдэс	тн	102.0	125.5	171.4	129.4	-42.0	-24.5

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	18.6	19.7	1.0	0.2	-0.8	-78.2
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.0	62.0	355.6	0.7	-354.9	-99.8
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	6.3	9.3	3.756	0.0	-3.8	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	72.8	48.5	30.0	29.3	-0.8	-2.5
Самнасан ноолуур	тн	24.4	17.9	355.1	102.7	43.8	74.4
Бохир ноолуур	тн	11.9	45.0	58.9	722.3	663.4	1,126.5
Хонины самнаагүй ноос	мян.тн	3.2	1.6	3.0	0.1	-2.9	-97.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	3 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	503.7	351.2	621.1	710.9	89.8	14.5
Нүүрс	641.7	252.4	688.7	675.6	-13.1	-1.9
Төмрийн хүдэр	106.5	141.1	238.5	57.5	-181.1	-75.9
Цайрын баяжмал	62.6	48.3	46.4	41.2	-5.2	-11.3
Алт	195.9	80.4	25.7	288.0	262.3	1022.5
Боловсруулаагүй нефть	87.8	17.7	78.4	0.0	-78.4	-100.0
Катодын зэс	13.7	17.3	27.3	7.4	-19.9	-72.8
Жоншны баяжмал	40.6	35.3	42.6	11.5	-31.1	-73.0
Адууны мах	10.6	5.5	8.6	0.0	-8.6	-100.0
Өлөн гэдэс	2.4	2.2	3.8	3.5	-0.3	-6.7
Үхэр, адууны боловсруулсан шир	1.8	1.8	0.4	0.12	-0.3	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.1	0.6	0.02	-0.6	-97.1
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.1	0.2	56.2	1.3	1.3	2.3
Ямаа, ишигний боловсруулсан арьс	2.4	2.0	1.0	0.5	-0.5	-47.5
Самнасан ноолуур	2.3	0.8	11.2	12.1	0.9	8.2
Бохир ноолуур	0.6	4.0	3.3	32.8	29.5	886.6
Хонины самнаагүй ноос	5.5	1.7	2.9	0.2	-2.7	-94.2
Нийт экспортод эзлэх хувь	94.7%	92.9%	90.0%	94.9%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **244.9** сая ам.доллар буюу **13.8** хувиар буурахад голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1.Нүүрс: 2022 оны эхний 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр **2.5** сая тонн нүүрс экспортолж, **675.6** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 4.1 сая тонноор, экспортын орлого 13.1 сая ам.доллараар буюу 1.9 хувиар буурсан байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 167.4 ам.доллар буюу 1.6 дахин нэмэгдсэн байна.

2.Зэсийн баяжмал: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувь буюу 89.8 сая ам.доллараар өсөж, **710.9** сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ **334.8** мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5.8 хувь буюу 18.5 мянган тонноор өссөн байна.

3.Төмрийн хүдэр: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ **616.2** мянган тонн болж, **57.5** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 75.9 хувь буюу 181.1 сая ам.доллараар буурахад төмрийн хүдрийн биет хэмжээ 67.8 хувь буюу 1.3 сая тонноор буурсан, нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 23.7 хувиар буурсан нь тус тус нөлөө үзүүлжээ.

4.Цайрын баяжмал: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ **21.9** мянган тонн болж, **41.2** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 11.3 хувь буюу 5.2 сая ам.доллараар буурахад цайрын баяжмалын биет хэмжээ 29.5 хувь буюу 9.1 мянган тонноор буурсан нь нөлөөлжээ. Хэдийгээр нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 25.7 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралт экспортын орлого буурахад нөлөөлжээ.

5.Алт: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ **4.8** тоннд хүрч, **288.0** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.9 дахин өссөн ба 2019 оны мөн үеэс 155.8 кг буюу 3.3 хувиар өссөн байна. Алтны экспортын орлого 288.0 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.2 дахин буюу 262.3 сая ам.доллараар өсжээ. Харин нэг тонн алтны экспортын дундаж үнэ 6.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

6.Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр катодын зэсийн экспортын тоо хэмжээ **0.8** тонн болж, **7.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2020 оны мөн үеэс 57.0 хувь буюу 9.9 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 72.8 хувь буюу 19.9 сая ам.доллараар тус тус буурсан. Нэг тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 11.8 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралт экспортын орлого буурахад нөлөөлжээ.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **22.9** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.1** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **386.5** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **109.7**

сая ам.доллараар буюу 39.6 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **1,304.2** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 57.3 сая ам.доллар буюу 4.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	3 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	315.4	284.0	276.8	386.5	109.7	39.6	22.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	970.3	877.5	1,246.9	1,304.2	57.3	4.6	77.1
Нийт импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	167.0	11.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн **22.9** хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг **15.9** хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл **15.4** хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги **13.1** хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн **9.4** хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн **7.4** хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2021.03	2022.03	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	25.6	41.1	15.5	60.7	2.4
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	83.6	38.4	-45.1	-54.0	2.3
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	14.8	13.6	-1.3	-8.5	0.8
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	123.7	167.3	43.6	35.2	9.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	276.8	386.5	109.7	39.6	22.9
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	97.4	124.7	27.3	28.1	7.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	57.8	68.8	11.0	19.1	4.1
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.5	1.6	0.2	13.0	0.1
9	Мод, модон эдлэл	8.8	21.1	12.3	140.3	1.3
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	14.7	20.8	6.0	41.0	1.2
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	22.3	33.4	11.1	49.6	2.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	4.7	6.7	2.0	41.8	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	31.7	42.5	10.9	34.3	2.5
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.9	2.7	0.8	44.8	0.2
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	99.8	159.2	59.4	59.5	9.4
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	263.0	269.1	6.1	2.3	15.9
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	346.7	222.0	-124.7	-36.0	13.1
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг тэдгээрийн эд анги	28.6	39.0	10.4	0.0	0.0
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	1.5	0.4	-1.1	0.0	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	19.0	31.9	12.9	0.1	0.0
	ДҮН	1,523.7	1,690.7	167.0	11.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага Сангийн сайдын 2022.03.01-ний өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 51 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөгөөр 2022 оны 03 дугаар сард улсын төсөвт

952.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 916.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 96.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.03		2022.03		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь	
Нийт орлого	790.3	952.7	916.2	125.9	115.9	-36.5	96.2	
Гаалийн албан татвар	203.8	245.1	245.7	41.9	120.6	0.6	100.2	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	417.0	505.4	502.7	85.7	120.6	-2.7	99.5	
Архи, дарсны онцгой албан татвар	4.1	5.7	5.6	1.5	136.6	-0.1	98.2	
Тамхины онцгой албан татвар	27.7	28.7	33.7	6.0	121.7	5.0	117.4	
Шар айрагны онцгой албан татвар	0.9	0.5	0.9	0.0	100.0	0.4	180.0	
Суудлын автомашины онцгой албан татвар	50.7	62.7	57.1	6.4	112.6	-5.6	91.1	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	67.6	83.6	57.2	-10.4	84.6	-26.4	68.4	
Автобензин, дизель түлшний албан татвар	3.3	3.1	4.9	1.6	148.5	1.8	158.1	
Экспортын татвар	0.024	0.002	0.01	-0.01	0.00	0.01	0.0	
Татварын дүн	775.1	934.8	907.8	132.7	117.1	-27.0	97.1	
Өөрийн орлого	1.0	4.5	1.9	0.9	190.0	-2.6	42.2	
Хураамж	14.2	13.4	6.5	-7.7	45.8	-6.9	48.5	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **125.9** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **41.9** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **85.7** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **1.5** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **6.0** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **6.4** тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар **1.6** тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар **10.4** тэрбум төгрөг, хураамжийн орлого **7.7** тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тус барааны онцгой албан татвараар 2022 оны 1 дүгээр улиралд 62.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 57.2 тэрбум төгрөг төвлөрүүлж 91.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй орлогыг харьцуулахад 6.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 14,627 ширхгийг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 542 ширхэг буюу 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс, хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 1,117 ширхгээр буурсан бол, бусад суудлын автомашин 575

ширхгээр өсчээ. Ногдуулсан татварын хэмжээг авч үзвэл:

- Автобензин, дизелийн хөдөлгүүрээр ажилладаг автомашин /цаашид "бусад" гэх/ онцгой албан татвартай автомашин – 19.8 тэрбум төгрөг;
- Хос тэжээлт болон, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин – 37.6 тэрбум төгрөг тус тус ногдуулжээ.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Импортын тоо хэмжээ				Ногдуулсан татвар			
	Төрөл	2021.03	2022.03	Зөрүү	Хувь	2021.03	2022.03	Зөрүү
Хос тэжээлт	12,004	10,887	-1,117	90.7	35.1	37.6	2.5	107.1
Бусад	3,165	3,740	575	118.2	15.8	19.8	4.0	125.3
Нийт	15,169	14,627	-542	96.4	50.9	57.5	6.6	113.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлш: Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үед 379.6 мянган тонн, 2022 оны 1 дүгээр улиралд 394.8 мянган тонн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Гаалийн байгууллага улсын төсөвт 2022 оны 1 дүгээр улиралд автобензин, дизелийн түлшний онцгой албан татвараар 83.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 57.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь 68.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар			
		2021.03	2022.03	Зөрүү	Хувь	2021.03	2022.03	Зөрүү	Хувь
Нийт		379.6	394.8	15.2	104.0	66.6	52.0	-14.6	78.1
Автобензин	A-80	12.1	10.3	-1.8	85.1	0.0	0.0	0.0	0.0
	A-92	94.7	160.7	66.0	169.7	0.0	0.0	0.0	0.0
	A-95 болон түүнээс дээш	3.8	7.1	3.3	186.8	0.8	1.5	0.7	183.7
Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин		0.0	14.4	14.4	100.0	0.0	2.5	2.5	100.0
Дизель түлш		269.0	202.3	-66.7	75.2	65.8	48.0	-17.8	72.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хураамжийн орлого: Гаалийн байгууллага улсын төсөвт хураамжийн орлогоор **13.4** тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс **6.5** тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 48.5 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 7.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортод гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн орлогын 92.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого /мянган тонн, сая төгрөг/

Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа	2021.03		2022.03		Өөрчлөлт 2022/2021	
	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж
Жонш	194.2	291.2	50.9	76.4	-143.3	-214.9
Төмрийн хүдрийн баяжмал	1,912.6	2,868.8	308.8	463.2	-1,603.7	-2,405.6
Зэсийн баяжмал	316.3	474.5	616.2	924.3	299.8	449.8
Цайрын баяжмал	31.0	46.5	334.8	502.3	303.9	455.8
Чулуун нүүрс	6,671.8	10,007.7	2,523.2	3,784.7	-4,148.7	-6,223.0

Хүрэн нүүрс	102.0	152.9	-	-	-102.0	-152.9
Түүхий нефть/мянган баррель/	1,422.1	2.1	-	-	-1,422.1	-2.1
Бусад		50.8			-	-50.8
Нийт		13,894.6			5,750.8	-8,143.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр **158.8** тэрбум төгрөг буюу нийт импортын 3.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 766.9 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн

импорт 320.6 тэрбум төгрөгөөр буюу 33.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **7.8** нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.03	2022.03	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	3,828.5	4,595.4	766.9	120.0%
<i>Эзлэх хувь</i>	<i>88.9%</i>	<i>96.7%</i>	<i>7.8%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	479.4	158.8	-320.6	33.1%
<i>Эзлэх хувь</i>	<i>11.1%</i>	<i>3.3%</i>	<i>-7.8%</i>	
Нийт импорт	4,307.9	4,754.2	446.2	110.4%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 158.8 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 27.3 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 51.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-ийн хүрээнд 42.8 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **10.9** тэрбум төгрөгийн татвар;
2. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 26.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **3.6** тэрбум төгрөгийн татвар;
3. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 35.4 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **5.2** тэрбум төгрөгийн татвар;
4. Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж 21.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **3.4** тэрбум төгрөгийн татвар;
5. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 22.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **3.1** тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Д/д	Үзүүлэлт	2021.03		2022.03		Өөрчлөлт 2022/2021	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	230.2	35.4	0.0	0.0	-230.2	-35.4
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	60.4	15.0	42.8	10.9	-17.6	-4.2
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	48.9	7.6	26.7	3.6	-22.2	-4.0
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	22.2	3.5	0.6	0.1	-21.6	-3.3
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	21.3	3.1	35.4	5.2	14.0	2.1
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	10.7	1.7	21.7	3.4	10.9	1.7
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	1.2	0.2	1.5	0.2	0.3	0.1
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	0.0	0.0	7.5	0.8	7.5	0.8
9	Бусад	84.5	12.6	22.7	3.1	-61.9	-9.5
	Дүн	479.4	79.1	158.8	27.3	-320.6	-51.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

Импорт: Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар илүү байна.

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолын дагуу үүрэг болгосноор Гаалийн байгууллага гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлсэн. Тухайлбал, Замын-Үүд дэх гаалийн газар чингэлэг терминалын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан уртасгасан цагаар ажиллаж, ААН, иргэдийн ачааг олгож байна.
- Коронавируст цар тахлын улмаас БНХАУ-ын Эрээн хотын боомтын бараа эргэлтийн хязгаарлалтаас хамаарч агаарын тээвэрлэлт 4-5 дахин өссөн үзүүлэлтэй байна. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар уртасгасан цагаар ажиллаж байна.

Татварын чөлөөлөлт: Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2021 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан (хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, малын тэжээлийг Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж ирсэн оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис амны хаалтыг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай) хуулиудын дагуу нийт 45.3 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлснөөс шалтгаалсан байна.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС